

БАНКНЫ САЛБАРЫН АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН-2023



Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг
хөгжүүлэх нь

Б.Баярдаваа

Мөнгөний бодлогын газрын захирал
МОНГОЛБАНК

Сүхбаатар аймаг

2023 он


МОНГОЛБАНК

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт (НСС)


- **НСС нь** авлага, тоног төхөөрөмж, бараа материал, ирээдүйд орж ирэх орлого */авлага/* зэрэг **Хөдлөх хөрөнгө барьцаалан эргэлтийн хөрөнгийн зээл, санхүүжилт авах** үйл ажиллагааны гол бүрэлдэхүүн хэсэг юм.
- НСС нь **авлага, бараа материал** болон сүлжээнд/харилцаанд оролцогчдын хоорондын **харилцаа холбоог** ашиглан гишүүдэд санхүүжилт олгох үйл ажиллагаа бөгөөд ингэснээр тэдэнд эргэлтийн хөрөнгө болон бэлэн мөнгөний урсгалаа оновчтой хэмжээнд байлгах боломжийг олгодог.

НСС нь уламжлалт зээл, санхүүжилтийн харилцаанаас ялгарах нь

Уламжилалт санхүүжилт



Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт



Уламжилалт санхүүжилт

НСС-ийн ерөнхий ойлголт: Оролцогчид тэдгээрийн харилцаа

Схем 1. НСС-д оролцогч талууд, тэдгээрийн харилцаа




НСС нь уламжлалт зээл, санхүүжилтийн харилцаанаас ялгарах нь

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн жишээ




НСС нь сүлжээн дэх харилцаа холбоон дээр түшиглэн хөрөнгийн захаас эх үүсвэр татах боломжтой




НСС-ийн жишээ

Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт Жишээ 1: Ханган нийлүүлэгчийн санхүүжилтийн схем



НСС-ийн жишээ


Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт Жишээ 2: Ханган нийлүүлэгчийн/Худалдан авалтын санхүүжилтийн схем



* - Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санд

НСС-ийн жишээ

Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт Жишээ 3: Худалдан авагч/Борлуулагчийн санхүүжилтийн схем



* - Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санд

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт (НСС)

- НСС нь түгээмэл бөгөөд үр ашигтай санхүүгийн бүтээгдэхүүн болдог нь дараах гурван шалтгаантай холбоотой:
 - ✓ Зээлдүүлэгчид, санхүүгийн байгууллагуудын зүгээс зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгийн шилжилт, гүйлгээний талаар **бүрэн мэдээлэлтэй** байхыг хүсдэг
 - ✓ Бизнес эрхлэгч зээлдэгчид өөрсдийн **“үйл ажиллагааны мөчлөгт”** тааруулан зээл олгохыг зээлдүүлэгчдээс хүсдэг
 - ✓ ЖДБ-үүд ерөнхийдөө үл хөдлөх хөрөнгө багатай байдаг (*Зүүн азид хийсэн судалгаанд жижиг бизнес эрхлэгч нарын 82% нь өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй байрыг эзэмшдэггүй гэж гарсан байна*)
- НСС-нд ерөнхийдөө дөрвөн төрлийн үйлчилгээг хамруулдаг: **Зээл, эрсдэл бууруулах, зээлийн бус бүтээгдэхүүн, мэдээлэл хуваалцах.**
- Санхүүгийн байгууллагууд сүлжээнд оролцогч талуудын **харилцаа холбоо**, байр суурийг ашиглан **мэдээлэл олж авах, урамшууллын тогтолцоог хөгжүүлэх, үйл ажиллагааны зардалын оновчтой хэмжээг тодорхойлох**, мөн шаардлагатай бол гарах арга замыг төлөвлөнө.

НСС-ийн зах зээл дээрх гол тоглогчид


- Нийлүүлэлтийн сүлжээнд санхүүжилт өгч буй байгууллага бүр санхүүгийн байгууллага байдаггүй; эсвэл эсрэгээрээ ч байж болно.
- Сайн хөгжсөн зах зээл дээр хамгийн наад зах нь **дараах гол оролцогчид** байдаг. Үүнд:
 - ✓ Нийлүүлэлтийн сүлжээнд санхүүжилт олгож буй банкууд
 - ✓ Нийлүүлэлтийн сүлжээнд санхүүжилт олгож буй ББСБ-ууд, тусгай зөвшөөрөлтэй
 - ✓ Тэргүүлэх компани (зохион байгуулагч/хөтлөгч); хэрэв сүлжээнд том, голлох байр суурь эзэлдэг бол ихэвчлэн санхүүжилт олгох өөрийн охин компаниа (санхүүгийн компани) байгуулсан байдаг
 - ✓ Барьцаа хөрөнгөнд менежмент хийдэг компани
 - ✓ Нийлүүлэлтийн сүлжээний менежмент хийдэг компани
 - ✓ Технологи (цахим платформ), тоо мэдээлэл болон эрсдэлийг бууруулах шийдэл санал болгогч талууд – эдгээр нь заавал санхүүгийн байгууллагууд байх албагүй
 - ✓ Санхүүжүүлэгч, санхүүжилтийн сувгууд мөн хөрөнгө оруулагч нар

Ач холбогдол үр өгөөж

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт нь **ханган нийлүүлэгч болон худалдан авагч** талуудын санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлдэг.

- Бараа ханган нийлүүлэгч тухайн бараа бүтээгдэхүүний **авлагынхаа** тодорхой хувьтай тэнцэх урьдчилгаа санхүүжилт авна.
- Ханган нийлүүлэгчийн хувьд мөнгөн **хөрөнгийн урсгал** сайжирна. **Авлага эдийн засгийн эргэлтэд** орно.
- Санхүүгийн хүртээмж сайжирна. **Уламжлалт санхүүжилт**, зээлийн бүтээгдэхүүн нь **зээлдэгчийн санхүүгийн тэнцэл**, санхүүгийн чадавхад тулгуурлан олгогддог бол **НСС** нь бараа бүтээгдэхүүний **нөөц, авлага, дансны төлбөр** зэрэг активт суурилдаг.
- ЖДБ-ийн хүндрэлийг шийднэ. Санхүүжилтийн хомсдол /барьцаа, зээлжих чадамж, санхүүгийн мэдлэг, банктай харилцаа муу гэх мэт/.
 - ЖДБ-үүд ерөнхийдөө **үл хөдлөх хөрөнгө** багатай байдаг (*Зүүн азид хийсэн судалгаанд жижиг бизнес эрхлэгч нарын 82% нь өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй байрыг эзэмшдэггүй гэж гарсан байна*)
 - ОУСКийн үнэлгээгээр дэлхий дахинаа нийт **65 сая ААН 5.2 их наяд ам.долларын** санхүүжилтийн хэрэгцээгээ хангаж чадахгүй байна.
- Борлуулалтын сүлжээ найдвартай болно. Ханган нийлүүлэгч санхүүжилтийн таатай боломжоор хангагдахын хэрээр худалдан авагч тал нь өөрийн ханган нийлүүлэгчдийн бааз суурийг найдвартай бүрдүүлэх, зохион байгуулах боломжтой болдог.
- Худалдан авагч тал нь нийлүүлэгч талд төлөх **төлбөрийн нөхцөлөө өөрчлөх**, өөрийн боломжид тааруулан хугацааг сунгах боломж үүсдэг.
- ЖДБ-үүдийн хувьд томоохон **худалдан авагчийн нэр хүндээр** санхүүжилт авах бололцоог НСС олгодог.
- Бодитоор төлөх зээлийн хүүний зардал буурна. Шаардлагатай үедээ авлагадаа тулгуурлан санхүүжилт авах боломжтой тул яг хэрэгтэй үедээ хурдан шуурхай санхүүжилт авах бололцоог үүсгэнэ.
- Банк, санхүүгийн байгууллагад учирч болзошгүй зээлийн эрсдэл буурна.
 - НСС олгох гол үндэс нь ханган нийлүүлэгч, худалдан авагчийн хоорондын **худалдах, худалдан авах тогтвортой харилцаа** байдаг.
 - Үйл ажиллагааны харилцааг даган **мэдээллийн урсгал илүү** сайн болдог

МУ-ын хувьд НСС-ийн хөгжүүлэхэд оролцогчид, тэдгээрийн үүрэг



Зохицуулагч болон ЗГ-ын байгууллагуудтай

- Зах зээлийн судалгаа, мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа
- НСС-ийг сурталчлах, гол оролцогч талуудын чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа
- НСС-тэй холбоотой тусгайлсан бодлого, журам боловсруулахад зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэх
- ЗГ-ын холбогдох яамд, байгууллагуудын хооронд НСС-тэй холбоотой яриа өрнүүлэх, хурал, зөвлөгөөн, сурталчилгааны хөтөлбөр, бодлого боловсруулахад хамтран ажиллах.

Үйлчилгээ үзүүлэгчид болон НСС-ийн харилцагчид, хэрэглэгч нартай

- Тэргүүлэх компаниуд, ханган нийлүүлэгчид, борлуулагч нарыг сургах
- Хөндлөнгийн гуравдагч талын үйлчилгээний ашиг тусыг сурталчлах
- Цахим платформ, барьцаа хөрөнгөнд менежмент хийх үйл ажиллагаа, хөгжүүлэлтийг дэмжих
- Санхүүгийн байгууллагууд, тэргүүлэх компаниуд, үйлчилгээ үзүүлэгч нарыг холбох, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Санхүүгийн байгууллагуудтай

- Салбарын хүрээнд хурал зөвлөгөөн сургалт зохион байгуулах, зарим нэг голлох үүрэг гүйцэтгэх байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх
- Санхүүгийн болон санхүүгийн бус салбарт үйл ажиллагаа явуулах холбогдох бизнес холбоодыг хөгжүүлэх
- Зах зээлийн стандарт, үйл ажиллагааны заавар, баримт бичгүүдийг боловсруулах
- НСС-тэй холбоотой гарын авлага, заавар зөвлөмжийг боловсруулах

Хөдлөх хөрөнгө барьцаалсан санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх нь

Хөдлөх эд хөрөнгийг барьцаалах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, ялангуяа ЖДБ-үүдийн хөрөнгө оруулалт, зээлийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх нэн чухал хөшүүрэг юм.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө: *тоног төхөөрөмж, бараа материал, авлага, ирээдүйд орж ирэх орлого /авлага/, гэрээ, оюуны өмч, бусад барьцаалж болох хөдлөх хөрөнгө, г.м*

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай **хууль батлагдан 2017 оны**

3-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн


Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх **цахим мэдээллийн сан байгуулагдсан**

Банк санхүүгийн байгууллагуудыг хөдлөх хөрөнгө барьцаалан зээл олгох **аргачлал үйл ажиллагаанд сургах** арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна

Хөдлөх хөрөнгө барьцаалсан санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх нь

- Нийт 400 гаруй мянган хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл бүртгэгдсэн (**400 гаруй мянган хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл**)

Барьцааны зүйл:



- 400 мянган барьцааны мэдэгдэл (160 гаруй мянга нь бизнесийн үйл ажиллагаатай холбоотой)
- Нийт зээлдэгчдийн 25% эмэгтэйчүүд
- Нийт хайлт – 500 мянга
- 80 мянга гаруй Бичил болон ЖДБ-үүд


- Банкны салбарын ЖДБ-үүдэд олгосон нийт зээлийн багцын - **16.07% хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл**.
- Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй судалгаа-2018 (Doing Business Report-2018)” – Зээл, санхүүжилт авах үзүүлэлт **62-оос 20 дугаар байранд** шилжсэн.
- Ойролцоогоор **8.0 тэрбум** төгрөгийн үйлчилгээний орлогыг Улсын төсөвт төвлөрүүлсэн.
- Цаашид хөдлөх хөрөнгийн санхүүжилтийг бизнесийн зориулалтаар, ялангуяа НСС байдлаар хөгжүүлэх шаардлагатай байна.**

НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ АНХААРАХ АСУУДЛУУД

- Олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх. МБ, СЗХ, Банк, ББСБ, зээлдэгч, Зээлийн эдийн засагч, хянан шалгагч, эрсдэлийн менежер гэх мэт
- Хууль, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох. НСС-ийг нэвтрүүлэхийг хязгаарласан хууль, эрх зүйн зохицуулалт бий эсэхийг нягтлах.
- Авлага барьцаалсан зээлийн бүтээгдэхүүний онцлогийг зохицуулагч байгууллага ойлгож, шаардлагатай зохицуулалтыг хийх нь чухал.
 - Авлагыг хөдлөх хөрөнгийн адилаар барьцаа хөрөнгөд тооцох
 - Давхар үл хөдлөх хөрөнгө шаардахгүй байх
 - Авлага барагдуулж зээлийн төлбөр төлөх тал эсвэл анх зээл авсан талын алийг нь зээлдэгч гэж үзэхийг нэг мөр тодорхой болгох
 - Авлага барагдуулагч талын зээлжих зэрэглэлээр зээлдэгчийн үнэлгээг хийх
- Банкны зохицуулалтаар дэмжих. ЖДБ-ийг дэмжих, шинэ санхүүгийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх.
- Тусгай сангууд болон бодлогын зээлийн эх үүсвэрээс НСС-нд тодорхой хэмжээгээр зарцуулах.
- Векселийг ашиглан НСС-ийг нэвтрүүлэх чиглэлээр банк болон ААН-үүдтэй хамтран ажиллах.
- Төв банк эсвэл/ба Засгийн газар олон улсын хөгжлийн банкуудтай энэ чиглэлээр хамтран ажиллах бололцоог эрэлхийлэх.

НСС-ийн боломж: Монгол улсын махны зах зээл

Зураг 4. Махны салбар дахь нийлүүлэлтийн сүлжээний дүрслэл



Эх сурвалж: Судалгааны үр дүн, тооцоолол 2018 оны тоон мэдээлэл дээр үндэслэсэн болно.


Хүснэгт 3. Махны салбарын нийлүүлэлтийн сүлжээнд тулгарч буй бэрхшээлүүд, тэдгээрийг сүлжээнд оролцогчдын зүгээс үнэлсэн байдал

	Малчид	Зуучлагчид	Боловсруулах үйлдвэрүүд	Бөөний зах	Борлуулагчид
Гэрээний хэрэгжилт					
Дэд бүтэц					
Улс төр, төрийн байгууллагатай харилцах					
Байгалийн гамшиг, бэлчээрийн доройтол					
Санхүүжилт					
Малын өвчин, стандарт эрүүл ахуй					

Маш хүндрэлтэй Хүндрэлтэй Шийдэж болохуйц

Эх сурвалж: Судалгааны үр дүн


Зураг 5. Махны салбарын нийлүүлэлтийн сүлжээн дэх санхүүжилт, төлбөрийн урсгалын дүрслэл



Улаанбаатар

НСС-ийн боломж: Махны зах зээл


Зураг 8. Борлуулагчийн санхүүжилтийн схем-2



Эх сурвалж: Судалгааны үр дүн


Авлага дээр суурилсан эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн бүтээгдэхүүн

Зураг 6. Ханган нийлүүлэгчийн санхүүжилтийн схем-1



Эх сурвалж: Судалгааны үр дүн

Зураг 9. Бараа материал барьцаалсан зээл




Эх сурвалж: Судалгааны үр дүн

Урьдчилсан судалгаа

НСС-ийн боломж: Монгол улсын ноолуурын зах зээл

Зураг 14. Ноолуурын салбарын нийлүүлэлтийн сүлжээний дүрслэл




Хүснэгт 6. Ноолуурын салбарын нийлүүлэлтийн сүлжээнд тулгарч буй бэрхшээлүүд, тэдгээрийг сүлжээнд оролцогчдын зүгээс үнэлсэн байдал

	Малчид	Зуучлагчид	Боловсруулах үйлдвэрүүд
Санхүүжилт			
Гадаад зах зээл дэх сурталчилгаа			
Байгалийн гамшиг, бэлчээрийн доройтол			
Гэрээний хэрэгжилт			
Маш хүндрэлтэй			
Хүндрэлтэй			
Шийдэж болохуйц			

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Зураг 15. Ноолуурын салбарын нийлүүлэлтийн сүлжээн дэх санхүүжилт, төлбөрийн урсгалын дүрслэл




Эх сурвалж: Судалгааны үр дүн

НСС-ийн боломж: Ноолуурын зах зээл


Хүснэгт 7. Ноолуур хөтөлбөрийн зээлийн нөхцөл

	Голомт банк Ноолуур хөтөлбөрийн зээл /2016 он/	Хаан банк Ноолуур хөтөлбөрийн зээл /2020 он/	Худалдаа хөгжлийн банк Бизнесийн зээл /2021 он/
Зээлийн хэмжээ	дундажаар 1.4 тэрбум (20 сая-7 тэрбум)	-	-350 сая хүртэл -350 саяас дээш
Зээлийн хүү /жилийн/	8 %	3%	19.2-22.8 хувь
Зээлийн хугацаа	12-48 сар	12 сар хүртэл	36 сар хүртэл /ЭХ/ 60 сар хүртэл /ХО/
Барьцаа хөрөнгө	Үл хөдлөх хөрөнгө (орон сууц, үйлдвэрийн барилга), газар, худалдан авах ноолуур, самнасан ноолуур, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж	Энгийн зээлээс ялгаагүй. Нийт зээлийн дүнгийн 60% нь үл хөдлөх хөрөнгө, 40% нь хөдлөх хөрөнгө байна. Тухайлсан томоохон харилцагчийн хувьд энэ харьцааг өөрөөр шийдвэрлэх тохиолдол байдаг.	Үл хөдлөх хөрөнгө (орон сууц, үйлдвэрийн барилга), газар, худалдан авах ноолуур, самнасан ноолуур, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж
Зээлийн эргэн төлөлт, хөнгөлөлт	Бусад зээлийн төрөлтэй адил, тэнцүү төлөлттэй байдаг, заримдаа үндсэн төлбөрөөс 6-12 сар хүртлэх чөлөөлнө	12 сар хүртэл 6 сар хөнгөлөлтийн хугацаа авч болно.	6 сар хүртэл үндсэн төлбөрөөс чөлөөлнө, тэнцүү төлөлттэй

Зураг 17. Захиалга барьцаалсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийн зээл



Зураг 10. Лоер факторт санхүүжилтийн схем



Анхаарал хандуулсанд
баярлалаа

ᠠᠨᠬᠠᠭᠠᠷᠠᠯ ᠬᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠤᠰᠠᠨᠳ
ᠪᠠᠶᠠᠷᠯᠠᠯᠠᠭᠠ